



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 01 . 24 № 1/127

танай _____-ны № _____-т

Шийдвэр хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны “Аргачлал батлах тухай” А/17 дугаар тушаалыг хүргүүлэв.

Тушаалаар баталсан “Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэдийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцоход баримтлах аргачлал”-ыг мөрдөж, иргэдийг 2014 оны 02 дугаар сарын 01-нээс 2014 оны 06 дугаар сарын 01-ний хооронд бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулах, чирэгдэл, хүндрэл гаргахгүй ажиллахыг Та бүхэнд үүрэг болгож байна.

Хувийг Мэдээллийн технологийн төвд.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/196 дугаар тушаалын хуулбарыг хавсаргав.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА



Ц.УРТНАСАН



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 23 өдөр

Дугаар A/117

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн “Гурав” дахь хэсгийн 15-ын “а”, 16-гийн “к” заалт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/57 дугаар тушаалаар баталсан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2013 оны А/196 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэдийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцоход баримтлах аргачлал”-ыг нэгдүгээр, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах өргөдөл гаргагчийн мэдүүлэг”-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан аргачлалыг хэрэгжүүлэх талаар аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, бүртгэл, баталгаажилтын хуудас, өргөдөл гаргагчийн мэдүүлгийг нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газар /Ц.Дашдондог/-т даалгасугай.

Гурав. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулснаар нэмэгдэх тэтгэврийн хэмжээг тооцож, шаардагдах хөрөнгийг 2015 оны Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөлд тусгахыг Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газар /Ч.Чулуунчимэг/-т, аргачлалын дагуу шаардлагатай програм хангамжийг 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсруулж, хэрэгжүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д тус тус даалгасугай.

Дөрөв. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт ДААЛГАХ нь:

4.1. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-д хамрагдах тэтгэврийн наснаас өмнө 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдыг 2014 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүртгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлүүлэх ажлыг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах;

4.2. Бүртгүүлсэн тэтгэвэр авагчдад баталгаажилтын хуудсыг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор олгох арга хэмжээ авах.

Тав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /Д.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2014 оны 117 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР 1991-1994 ОНУУДАД ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН
ИРГЭДИЙН АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН
ТООЦОХОД БАРИМТЛАХ АРГАЧЛАЛ**

Нийтлэг үндэслэл

1.1. Дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эсхүл олон жил ажилласан нөхцөлөөр нас харгалзахгүйгээр, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл (цаашид хөнгөлөлттэй нөхцөл гэх)-өөр 1991-1994 онуудад тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийг “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-д хамруулан бүртгэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлүүлэх, баталгаажуулахад энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэдийг “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-д хамруулан бүртгэхдээ ажлаас халагдсан шалтгааныг үндэслэхгүй ба энэ аргачлалын 2.1-д заасныг баримтална.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхээс өмнө дагаж мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу 1991-1994 онуудад дараах байдлаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хугацааг бүртгэнэ. Үүнд:

а/ Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн эхчүүд 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн, эсхүл 20-иос доошгүй жил ажиллаж нас харгалзахгүйгээр;

б/ Нийтдээ 32-оос дээш жил ажиллаж, 55 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;

в/ 27-гоос дээш жил ажиллаж нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд;

г/ Нийтдээ 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор болон хортой, халуун нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;

д/ 15-аас доошгүй жил, түүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар хортой, халуун нөхцөлд ажиллаж, 40 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд;

е/ 25-аас доошгүй жил, түүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 50 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;

ж/ 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд.

2.2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдыг “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-д хамруулахдаа тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас буюу эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүртэл хугацаагаар нөхөн тооцох ба энэ хугацаа нь 1997 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл байна.

Жишээ №1: Иргэн “В” эмэгтэй, 1992 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 41 насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол нийтдээ 5 жил (1992 оны 2-12 сар, 1993 оны 1-12 сар, 1994 оны 1-12 сар, 1995 оны 1-12 сар, 1996 оны 1-12 сар, 1997 оны 1 сар)-ийг нөхөн тооцуулна.

Жишээ №2: Иргэн “Г” эрэгтэй, 1993 онд 55 настайдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол нөхөн тооцуулах жил нь 4 жил 1 сар байна.

Гурав. Бүрдүүлэх баримт бичиг, бүртгэл, баталгаажуулалт

3.1. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулах хүсэлтээ өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа аймаг, дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө. Үүнд:

а/ Иргэний үнэмлэх, түүний хуулбар

б/ Өргөдөл гаргагчийн мэдүүлэг (бөглөж, гарын үсэг зурсан байх)

3.2. Аймаг, дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) бүртгэлийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

а/ Тухайн тэтгэвэр авагч нь өргөдөл гаргагчийн мэдүүлгийг үнэн зөв бөглөсөн эсэхийг шалгаж, хүсэлтийг нь хүлээн авсан он, сар, өдрийг мэдүүлэгт тодорхой бичиж, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулахтай холбогдолтой мэдээллийг “Иргэн (даатгуулагч)-ий ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай бүртгэл”-д үнэн зөв бүртгэж дугаарлах;

б/ Хүсэлт гаргасан тэтгэвэр авагчийн тэтгэвэрт гарсан үндэслэл энэ аргачлалын 2.1.-д дурдсантай нийцэж байгаа эсэхийг тэтгэврийн хувийн хэрэгт байгаа холбогдох баримт бичигтэй тулган шалгах;

в/ Хүсэлт гаргасан тэтгэвэр авагчийн бүртгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт сар бүрийн 10-ны дотор цахим хэлбэрээр ирүүлэх.

3.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн тэтгэвэр авагчийн бүртгэлийг нийгмийн даатгалын салбарын нэгдсэн цахим мэдээллийн сан, Иргэний бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэлтэй тулган, сар бүрийн 25-ны дотор нягтлан шалгаж, баталгаажуулан аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэст буцаан хүргүүлнэ.

3.4. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэвэр авагчийн 1991 оноос 1997 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилласнаар нөхөн тооцсон болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлсэн жил, сарыг "Баталгаажилтын хуудас", "Иргэн (даатгуулагч)-ийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэл"-ийн хуудсанд тус тус бичиж, баталгаажуулна.

3.5. Тухайн тэтгэвэр авагчийн нэр дээр бичигдсэн "Баталгаажилтын хуудас", "Иргэн (даатгуулагч)-ийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэл"-ийн хуудсыг түүний тэтгэврийн хувийн хэрэгт буй хөдөлмөрийн дэвтэр (архивын лавлагаа, шүүхийн шийдвэрээр ажилласан жилээ нотлуулсан бол хамгийн сүүлийн тэтгэвэр тогтоолтын хуудасны арын хэсэг)-ийн нэг хуудасны хоёр талд нь тус тусад нь наана.

3.6. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь бүртгүүлсэн тэтгэвэр авагчийн нэр дээр 1995-1997 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нөхөн тооцогдсон жил, сард ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10.0 хувиар тооцож тэтгэврийн даатгалын санд төлүүлнэ.

Тухайлбал: 1995-1997 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаа (2 жил, 1 сар)-ны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхээр тооцогдсон гэвэл тухайн тэтгэвэр авагчийн нөхөн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг дараах байдлаар гаргана.

Сар	Онууд		
	1995	1996	1997
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		
	9 600		
	Шимтгэл тооцох хувь- 10.0 хувь		
1	960	960	960
2	960	960	
3	960	960	
4	960	960	
5	960	960	
6	960	960	
7	960	960	
8	960	960	
9	960	960	
10	960	960	
11	960	960	
12	960	960	
Дүн	11,520	11,520	960
Бүгд	24,000		

Энэ тохиолдолд тухайн тэтгэвэр авагчийн 1995-1997 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нөхөн тооцуулсан 2 жил 1 сард ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг 24 000 төгрөгөөр тооцож тэтгэврийн даатгалын санд нэг удаа бөөнд нь төлүүлнэ.

3.7. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг санд нөхөн төлүүлсэн орлогын баримтыг тухайн тэтгэвэр авагчийн "...өргөдөл гаргагчийн мэдүүлэг" болон холбогдох баримттай хамт тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргана.

3.8. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь "Баталгаажилтын хуудас"-ыг үндэслэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй иргэний ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон хугацаанд ногдох тэтгэврийн нэмэгдлийг 2015 оны 01 дүгээр 01-нээс тооцон олгож эхэлнэ.

----- оОо -----

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2014 оны / / дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦУУЛАХ
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

Мэдүүлгийн дугаар		Тэтгэврийн дэвтрийн дугаар	
	<input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>	Он	<input type="text"/> <input type="text"/>
		Сар	<input type="text"/> <input type="text"/>
			өдөр

1. ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН:

Овог _____ Эцэг (эх)-ийн нэр _____ Өөрийн нэр _____

Регистрийн дугаар:

ХОЛБОО БАРИХ ХАЯГ, УТАСНЫ ДУГААР:

2. ӨРГӨДӨЛ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ: (ТОХИРОХ ЗААЛТЫГ СОНГОН ✓ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙНЭ)

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн эхчүүд 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн, эсхүл 20-иос доошгүй жил ажиллаж нас харгалзахгүйгээр;
- Нийтдээ 32-оос дээш жил ажиллаж, 55 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 27-гоос дээш жил ажиллаж нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд;
- Нийтдээ 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор болон хортой, халуун нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 15-аас доошгүй жил, түүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар хортой, халуун нөхцөлд ажиллаж, 40 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд;
- 25-аас доошгүй жил, түүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 50 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд.

6. АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ НӨХӨН ТООЦУУЛАХ ХУГАЦАА: (ТОХИРОХ САРЫГ СОНГОН ✓ тэмдэглэгээ хийнэ)

Он	Сарууд												Нийт
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1991													
1992													
1993													
1994													
1995													
1996													
1997	1997 оны 2 ба түүнээс хойш сард нөхөн төлөлт хийгдэхгүй												
Бүгд	(.....жил.....сар, төлсөн шимтгэлтөгсөг)												

Дээрх хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож өгнө үү.
Өргөдөл гаргагч би нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж барагдуулахаа нотолж байна.
Гарын үсэг: _____

(Доорхи хэсгийг тасалж, мэдүүлэг гаргагчид өгнө)

Өргөдөл хүлээн авсан: _____ аймаг (дүүрэг)-ийн

Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан: _____ / _____ /

Өргөдөл хүлээн авсан огноо: _____ он _____ сар _____ өдөр.

Мэдүүлгийн дугаар	
-------------------	--



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 526 тоот шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1.Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам"-ын 2.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 2.1.6 дахь заалт, 3.7 дахь хэсэг нэмсүгэй:

1/"2.1.6.Дөрөв ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж өсгөсөн, эсхүл олон жил ажилласан нөхцөлөөр нас харгалзахгүйгээр, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэврийн наснаас өмнө 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэн",

2/"3.7.Энэ журмын 2.1.6-д заасан тэтгэвэр авагчийн ажилласан хугацаа, тэтгэврийн даатгалын шимтгэлийг түүний тэтгэврийн нас хүртэлх хугацаагаар нөхөн тооцох ба энэ хугацаа нь 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүртэл байна.


2.Мөн журмын 2.1.4 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

"2.1.4.Тухайн онуудад энэ журмын 2.1.6-д зааснаас бусад хэлбэрээр нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоолгоогүй иргэн",

3.Мөн журмын 3.7-3.11 дэх хэсгийн дугаарыг 3.8-3.12 болгон өөрчилсүгэй.

4.Нийгмийн даатгалын байгууллага нь энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан иргэний ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцохдоо тухайн тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосон хувийн хэргийн материалыг үндэслэн 2014 оны 2 дугаар сарын 01-нээс 6 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэл, тооцоо хийж, нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлүүлж, баталгаажилтийн хуудсыг 2014 оны 9 дүгээр сарын 01-ний дотор олгохоор зохион байгуулж, 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгосугай.

САЙД



С.ЭРДЭНЭ